# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр | Дугаар 295 | Улаанбаатар хот

## Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дах заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлсэн “Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн төсөл”-ийн хүрээнд бий болсон нийт 3,479,535,645.13 (гурван тэрбум дөрвөн зуун далан есөн сая таван зуун гучин таван мянга зургаан зуун дөчин таван төгрөг арван гурван мөнгө) төгрөгийн үнэ бүхий хөрөнгө (өр төлбөр)-ийг хавсралтад заасны дагуу “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

132001717

16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 06 дугаар сарын 13...-ны өдрийн
..895.... дугаар тогтоолын хавсралт

"УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Хөрөнгийн нэр | Гэрээний дүн /гүйцэтгэлээр/ | Капиталжуулах дүн (төгрөг) | | | Хөрөнгөд бүртгэх дүн (төгрөг) |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Зээлийн шимтгэл | Зээлийн хүү | Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж | |
| 1 | Насос станцын №2-н өргөтгөл | 3,124,468,383.00 | 27,185,202.29 | 291,956,941.70 | 35,925,118.13 | 3,479,535,645.13 |
| Нийт дүн | | | | | | 3,479,535,645.13 |
| | | | | | | (гурван тэрбум дөрвөн зуун далан есөн сая таван зуун гучин таван мянга зургаан зуун дөчин таван төгрөг арван гурван мөнгө) |